

## 2014 ОНЫ 3 ДУГААР САРЫН 31-НИЙ БАЙДЛААР НОГДОЛ АШИГ ТАРААСАН ХК-ИУД

Санхүүгийн тайлант хугацаанд үйл ажиллагаанаас олсон ашгийг бусдын болон нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлан, хариуцлагатай хандаж хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нартаа ногдол ашиг хуваарилах уу эсвэл бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэн, сайжруулах зэрэгт хөрөнгө оруулалт хийх үү гэдэг асуудал ашигтай ажиллаж буй бүхий л аж ахуйн нэгж болон Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын өмнө тулгардаг билээ.


Компани нь олсон ашгаасаа хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагчиддаа бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн үнэт цаас хэлбэрээр ногдол ашиг болгон хуваарилж болохоор өнөөгийн мөрдөгдөж буй Монголын

Улсын хууль эрх зүйн хүрээнд заасан байдаг.

Тухайн компанийн удирдлага буюу Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл / байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ нь жил бүрийн эхний 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргаж хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх үүрэгтэй байдаг.

2014 оны 3-р сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй нийт 249 компанийн 17.7 % буюу 44 ХК хувьцаа эзэмшигчиддээ 2013 онд олсон ашгаасаа хуваарилах эсэх талаар ТУЗ-өөрөө хэлэлцэж, үүнээс хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг тараах шийдвэрээ ирүүлж, олон нийтэд мэдээлсэн 11 ХК-ийг зураг 1-т үзүүлэв.

### 2014 ОНД НОГДОЛ АШИГ ТАРААЖ БУЙ ХК-ИУД /нэгж хувьцаанд ногдох хэмжээгээр/



Зураг 1

Үүнд:

“Газар сүлжмэл” ХК нэгж хувьцаанд 7233.39 төгрөг, “Баянгол зочид буудал” ХК нэгж хувьцаанд

355 төгрөг, “Техник импорт” ХК нэгж хувьцаанд 200 төгрөг, “Говь” ХК нэгж хувьцаанд 130 төгрөг, “Талх чихэр” ХК нэгж хувьцаанд 110 төгрөг, “Мах импекс” ХК нэгж хувьцаанд 100 төгрөг, “Тахь ко” ХК нэгж хувьцаанд 65 төгрөг, “Би Ди Сек” ХК нэгж хувьцаанд 11.78 төгрөг, “Ачит алкабы” ХК нэгж хувьцаанд 10 төгрөг, “Гермес центр” ХК нэгж хувьцаанд 5.82 төгрөг, “Эрдэнэт суварга” ХК нэгж хувьцаанд 5 төгрөг тус тус хуваарилахаар болжээ.

2014 оны 3-р сарын 31-ний өдрийн байдлаар үлдэх 32 компани буюу 59.3% нь ногдол ашиг 2013 оны жилийн эцсийн санхүүгийн хуваарилах эсэх нь тодорхойгүй, холбогдох тайлангаа биржид 108 ХК ирүүлсний 50% буюу мэдээллийг биржид ирүүлээгүй байна.

54 ХК нь өнгөрөгч онд ашигтай ажиллаж, үүнээс 11 ХК нь 3.08 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчиддээ тараахаар шийдвэрлэсэн ба мөн тооны буюу 11 хувьцаат компани нь олсон ашгаа компанийн цаашдын үйл ажиллагааг сайжруулахад зориулж нэмэлт хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэсэн бол


Ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн 11 хувьцаат компанийн хувьд цэвэр ашгийнхаа хэдэн хувийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийн хэлбэрээр хуваарилж байгааг Хүснэгт 1, Зураг 2-т үзүүлэв.

Хүснэгт 1

Д/д	ХУВЬЦААТ КОМПАНИЙН НЭР	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ /ТӨГ/	НОГДОЛ АШГИЙН НИЙТ ДҮН /ТӨГ/	ЭЗЛЭХ ХУВЬ
1	Газар сүлжмэл	472,789,000.00	472,788,837.00	100.0%
2	Гермес центр	457,129,500.00	457,120,266.00	100.0%
3	Ачит алкабы	1,123,000.00	741,270.00	66.0%
4	Би Ди Сек	288,127,800.00	129,600,000.00	45.0%
5	Техник импорт	1,019,901,600.00	289,351,000.00	28.4%
6	Тахько	281,547,300.00	77,348,895.00	27.5%
7	Мах импекс	1,907,000,000.00	380,072,100.00	19.9%
8	Говь	7,102,877,200.00	1,014,146,250.00	14.3%
9	Талх чихэр	2,229,972,800.00	112,607,330.00	5.0%
10	Баянгол ЗБ	3,448,275,800.00	150,188,075.00	4.4%
11	Эрдэнэт суварга	(213,993,000.00)	780,270.00	-0.4%
	<b>НИЙТ</b>	<b>16,994,751,000.00</b>	<b>3,084,744,293.00</b>	

2014 оны 1 дүгээр улиралын байдлаар “Газар сүлжмэл”, “Гермес центр” ХК-иуд нь 2013 онд олсон цэвэр ашгаа 100% хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашгийн хэлбэрээр тараахаар шийдвэрлэсэн нь хамгийн өндөр хувьтай юм. “Баянгол зочид бүүдал” ХК-ийн хувьд 2013 оны цэвэр ашгийн зөвхөн 4.4%-ийг ногдол ашигт хуваарилсан нь хамгийн бага хувьтай компанид тооцогджээ. Харин “Эрдэнэт суварга” ХК нь өнгөрсөн онд алдагдалтай ажилласан хэдий ч хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Зураг 2



МХБ-д бүртгэлтэй компаниудын өнгөрөгч 2000-2014 онуудын ногдол ашиг тараалтын байдлыг Хүснэгт 2, Зураг 3-т тус тус үзүүлэв.

Хүснэгт 2

	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007
Нийт бүртгэлтэй ХК	418	410	400	403	395	392	387	384
Ногдол ашиг тараасан ХК	17	24	13	19	13	18	23	30
Нийтэд эзлэх %	4.1%	5.9%	3.3%	4.7%	3.3%	4.6%	5.9%	7.8%
Ногдол ашгийн үнийн дүн /тэрбум төгрөг/	2.93	3.61	2.39	1.94	0.89	0.83	3.82	7.35


	2008	2009	2010	2011	2012	2013	2014*
Нийт бүртгэлтэй ХК	376	358	336	332	329	261	249
Ногдол ашиг тараасан ХК	38	26	17	28	29	30	11
Нийтэд эзлэх %	10.1%	7.3%	5.1%	8.4%	8.8%	11.1%	4.4%
Ногдол ашгийн үнийн дүн /тэрбум төгрөг/	17.52	14.29	30.97	74.28	79.09	11.41	3.08

\* - 2014.03.14-ний байдлаар гаргасан тоон мэдээлэл

Эдгээр тоо баримтаас харахад МХБ-д бүртгэлтэй төдийгүй компанийн үйл ажиллагааны цар хүрээг компаниудын дийлэнхи хэсэг нь ашиг огт өргөжин тэлэх, зах зээлд эзлэх байр суурь, нэр тараадаггүй эсвэл маш бага хэмжээтэй ашиг хүндийг өсгөхөд нөлөөлдөг чухал хүчин зүйлсийн тараадаг болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл нэг юм. Мөн ногдол ашиг тараах нь компанийн ААН-үүдийн хуулиа эрхэмлэн дээдэлдэггүй, хувьцаа санхүүгийн болон хувьцааны ханшийн тогтвортой эзэмшигчид болон нийгмийн өмнө хүлээсэн байдлыг хангаж өгдөг чухал ач холбогдолтой. хариуцлагаа хангалттай ухамсарладаггүй, жижиг Иймдээ ч хөрөнгө оруулагчид ногдол ашгийн хувьцаа эзэмшигчдийг хохироодог болох нь тогтвортой бодлоготой, тогтмол ногдол ашиг хуваарилдаг, санхүүгээ үнэн зөв, ил тод тайлагнадаг тийм л компанийг сонирхон хөрөнгө оруулалт хийх нь элбэг байдаг.

Аливаа нээлттэй хувьцаат компанийн хувьд ногдол ашиг хуваарилах нь цаашид хөрөнгө босгох, гадаад, дотоодын санхүүжилтийн хүрээг нэмэгдүүлэхэд

Зураг 3





# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 15160, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-3;  
Факс: (+976)-11-325170; Утас: (+976)-11-313747, Цахим хуудас: [www.mse.mn](http://www.mse.mn); И-мэйл: [info@mse.mn](mailto:info@mse.mn)

## ХУВЬЦААТ КОМПАНИУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

МХБ-д бүртгэлтэй компаниудын ТУЗ, гүйцэтгэх удирдлага нар ногдол ашиг хуваарилалттай холбоотой дараах асуудлуудад анхаарал хандуулан, цаашдын үйл ажиллагаандаа зохих саналыг тусган ажиллах нь зүйтэй юм. Үүнд:

- ◆ Манай ихэнхи хувьцаат компаниудад ногдол ашгийн урт хугацааны бодлого байхгүйгээс хувьцаа эзэмшигчид тогтмол хугацаанд ногдол ашиг хүртэж чаддаггүй. Ногдол ашгийн бодлого, ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилах арга механизм нь ойлгомжтой, ил тод байх ёстой бөгөөд ТУЗ-өөс уг бодлогыг боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлан мөрдүүлэх нь зүйтэй.
- ◆ Ногдол ашиг тараах шийдвэртээ хуульд заасан мэдээллийг бүрэн тусгаж байх, шийдвэрийг нийтэд хүртээмжтэй мэдээлэх шаардлагатай. Тухайлбал, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдөр, ногдол ашиг олгож эхлэх ба дуусах хугацаа, нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ зэргийг шийдвэртээ тодорхой зааж өгөх хэрэгтэй.
- ◆ 2011 онд батлагдсан Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46.5-р заалтын дагуу ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор гаргах шаардлагатай түүнчлэн ногдол ашиг тараах ажиллагааг ҮЦТТХТ-өөр дамжуулан зохион байгуулах нь зүйтэй юм.
- ◆ Хувьцаат компани нь нийгмийн, хувьцаа эзэмшигчдийн, болон бусад оролцогч талуудын өмнө хариуцлагатай хандаж, компанийн засаглалын асуудалд буюу санхүүгийн үнэн зөв тайлагнал, мэдээллийн ил тод шүүрхай байдлыг ханган ажиллах тал дээр илүү анхаарч, зохих ажиллагааг сайжруулах хэрэгтэй байна.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн хувьд өөрийн хуулиар олгогдсон “ногдол ашиг авах” эрхээ эдлэх талаар анхаарал хандуулан, хөрөнгө оруулсан компани, түүний удирдлагуудад шаардлага тавин хяналттай, “идэвхитэй” хөрөнгө оруулагч байж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байхыг зөвлөж байна.

### БҮРТГЭЛИЙН АЛБА

Facebook page: Mongolian Stock Exchange

Бүртгэлийн алба: 976-11-310517 /119, 120, 134/

Мэдээллийн алба: 976-11-313747 /140, 109/